

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-21
1. “Халзан бүрэгтэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдвээр зохион байгуулсан ерөнхий хяналтын сонсголын тайлан	4-21

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хороодын хамтарсан
11 дүгээр сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 57 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан;

Чөлөөтэй: С.Амарсайхан, О.Амгаланбаатар, М.Бадамсүрэн, П.Батчимэг, Т.Мөнхсайхан, З.Мэндсайхан, Р.Сэддорж;

Эмнэлгийн чөлөөтэй: О.Батнайрамдал, Ж.Ганбаатар, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, П.Ганзориг, Б.Жавхлан, Б.Заяабал, Б.Найдалаа, О.Цогтгэрэл.

Нэг. “Халзан бүрэгтэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдвээр зохион байгуулсан ерөнхий хяналтын сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, шинжээч Т.Аззаяа, Х.Лхагвабаатар, Н.Наранцэцэг, М.Пүрэв-Очир, А.Хаумдас, Н.Уртнасан, Э.Цэрэнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг нар байлцав.

Сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Л.Мөнхбаясгалан, Х.Баасанжаргал, Н.Батсүмбэрэл, А.Ундраа, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, шинжээч Х.Лхагвабаатар, Н.Наранцэцэг нар харилж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Халзан бүрэгтэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдвээр зохион байгуулсан ерөнхий хяналтын сонсголын тайланг сонслоо.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 56 минут үргэлжилж, 57 гишүүнээс 34 гишүүн хүрэлцэн ирж, 59.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 12 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Жаргалан: Ирц бүрдсэн тул хурлаа эхлүүлье. Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Чинбаатарын Анар, Ренчиндоржийн Батболд, Жигжидийн Батжаргал, Шинэбаярын Бямбасүрэн, Мөнгөнцогийн Ганхүлэг, Гонгорын Дамдинням, Батбаярын Жаргалан, Сонгобайн Замира, Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Сүрэнжавын Лүндэг, Мэндбаярын Мандхай, Цагаанхүүгийн Мөнхбат, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Баатаржавын Мөнхсоёл, Бадрахын Найдалаа, Нанзадын Наранбаатар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Ганбатын Очирбат, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Цэвэгдоржийн Туваан, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн, Мөнхчулууны Энхцэцэг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 52,6 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороодын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал. Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцэх тухай.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцэж эхэлье.

Ерөнхий хяналтын сонсголын тайлангийн дэлгэрэнгүй хувилбарыг та бүхэнд тараасан байгаа. Ерөнхий хяналтын сонсгол явуулсан талаарх танилцуулгыг уг сонсголыг даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Баярбаатар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Б.Баярбаатар: Байнгын хорооны хурал даргалагч, эрхэм гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Халзан бүрэгтэй орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалтын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасны дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай 15/12 дугаар тогтоолоор Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдвээр ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулахаар тогтож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар миний бие томилогдсон.

Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд:

1. Сонсголын зарыг 2025 оны 8 дугаар сарын 6-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл parliament.mn цахим сүлжээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонсголд нийт 168 хүн оролцохоор бүртгүүлсэн.

2. Халзан бүрэгтэйн орд газрын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, тухайн аймаг, орон нутгийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бодит тайлбар санал мэдээллийг сонсох зорилгоор Ховд аймагт 2025 оны 9 дүгээр сарын 7-9-ний өдрүүдэд ажилласан. Мөн үеэр хүсэлт гаргасан төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэдийн төлөөлөлтэй уулзаж, санал бодлыг нь сонссон.

3. Халзан бүрэгтэйн орд газартай холбоотой асуудлаар холбогдох төрийн байгууллагуудаас баримт бичиг гаргуулан авч, шинжлэх ухаан нотолгоонд суурилсан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн 9 шинжээчийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 14 дүгээр тогтоолоор томилон ажиллуулсан.

Ерөнхий хяналтын сонсголын талаар:

Халзан бүргэдийн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус сонсголд нийт 132 хүн оролцлоо.

Сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизээр хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулан мөн сонсголыг хэвлэл мэдээллийн 13 сайт, 8 телевиз шуурхай дамжуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-д заасны дагуу сонсголд оролцож санал хэлэхээр хүсэлт гаргасан, бүртгүүлсэн бүртгүүлсэн Ховд аймгийн 24 иргэн, цахим хуудсаар саналаа ирүүлсэн 17 иргэн, заалнаас 19, нийт 60 иргэн үг хэлэв.

Сонсголд орон нутгаас болон иргэний нийгмийн байгууллагыг төлөөлж орсон оролцогчид төрийн байгууллага болон шинжээчдийн дүгнэлт илтгэлд дурдсан мэдээлэл хэт ерөнхий зарим асуудал тодорхой бус өмнө нь төрийн байгууллагаас гаргаж байсан зарим дүгнэлт төрийн бус байгууллагуудын хийсэн бие даасан судалгаа шинжээчийн гаргасан дүгнэлттэй зөрүүтэй мэдээлэлтэй байгаад анхаарах. Төслийн хайгуул судалгааны явцад байгаль орчинд онц ноцтой хохирол үзүүлж байгаа талаар гаргасан гомдлуудад төрийн байгууллагуудаас өгсөн хариулт, саналтай нийлэхгүй, тодорхой хариулт өгөхгүй нөхцөл байдалтай байхад төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж хайгуулыг үргэлжлүүлэхээр оролдсоор байгаа нь хууль зөрчиж байна гэсэн байр суурийг илэрхийлсэн.

2.Ховд аймгийн Мянгад сумыг төлөөлөн иргэн Г.Төрмөнх болон Ховд аймгийн Засаг дарга асан Г.Нямдаваа нар “Халзан бүрэгтэйн” орд газрын талаар танилцуулга бүхий мэдээллийг хийсэн.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д “гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.” гэж заасны дагуу сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ө.Шижир, Б.Уянга, С.Замира, Э.Болормаа, Ж.Золжаргал, З.Мэндсайхан, Ч.Лодойсамбуу, М.Бадамсүрэн, О.Амгаланбаатар, Б.Заяабал, Да.Цогтбаатар нар асуулт асууж, санал хэлсэн.

Гишүүд Халзан бүрэгтэйн ордын хувьд хайгуул судалгааны ажил эхэлсэн хэдий ч цаашид ашиглалт олборлолт явуулбал хэчнээн тонн хүдэр гараад, түүнийгээ хэрхэн баяжуулах, үлдэгдэл хаягдлын сангаас ямар хэмжээтэй цацраг идэвхт бодис тархаж тэр нь хүрээлэн буй орчин, хүн, мал, ан амьтан, экологид нөлөөлөх эсэх талаар тодорхой мэдээллүүдээр салбар яам агентлагуудад иргэдийг хангах хэрэгтэй гэв. Мөн цаашид сонсголын үр дүнд төр ямар нэгэн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон тусгай зөвшөөрлийг хамгаалах, ажиллах боломжоор нь хангах, эсвэл үйл ажиллагааг нь ямар шалтгааны улмаас зогсоох талаар тодорхой шийдвэр гаргаж, нийгмийг талцуулахгүй байхад анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн Монгол Улсын газрын ховор элементийг ашиглахад өөрийн бодлогыг тодорхойлж энэ салбарт гуравдагч улсуудын хөрөнгө оруулалтыг татах үндэсний эрх ашиг тул чиг үүргийн яамнуудаа газрын ховор элементийн бодлогыг тодорхойлох чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах, төсөв л хэрэгжүүлэхэд иргэдийн дунд ташаа ойлголт өгдөг салбарын зарим нийцэлгүй хуулийн зүйл заалтыг эргэж харах, баялгийн шударга хуваарилалтад анхаарах цаг болсныг өнөөдрийн нөхцөл байдал харуулж байгааг гишүүд дурдсан.

Мөн газрын ховор элементийн ашиглалттай холбоотой үйл ажиллагаа аюултай хортой гэдэг агуулга байнга дагалдаж байгаа учраас Монгол Улсын газрын ховор элементийг ашиглах эсэх талаар бодлогоо эргэж харах хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1.6-д “гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, З.Мэндсайхан нар үг хэлэв.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн дүгнэлт:

1.Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг Монгол Улсад газрын ховор элементийн чиглэлээр төрөөс барих бодлогыг тодорхойлсон;

2.Халзан бүрэгтэйн орд бол газрын ховор элементийн орд бөгөөд хайгуулын шатад явж байгаа бөгөөд цаашид ашиглалтад бэлтгэж байгаа төсөл юм.

3.Халзан бүрэгтэйн ордод диспрози, терби, неодим, паразиодин гэх 4 тогтмол соронзонгийн түүхий эд, газрын ховор элемент агуулагддаг бөгөөд эдгээр нь өөрөөсөө цацрах идэвхгүй.

4.Зах зээлийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй өнөө үед Халзан бүрэгтэйн газар ховор элементийн ордыг ашиглан түүхий эдийг нь дунд шат хүртэл боловсруулж, нийлмэл исэл үйлдвэрлэх нь өндөр ач холбогдолтой. Энэ нь ордын нөөцийг илүү үр ашигтай ашиглах, дотооддоо нэмүү өртөг шингээх улмаар дэлхийн тогтмол соронзонгийн зах зээлд урт хугацаанд урт хугацаанд найдвартай нийлүүлэгч болох боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулах чухал төсөл болох юм.

5.Байгалийн цацраг гэдэг нь ердийн ашигт малтмалын ордуудад ч байх бөгөөд Халзан бүрэгтэйн ордод агуулагдах уран 0,009% байгаа нь Монгол Улсын бусад газрын ховор элементийн ордоос бага үзүүлэлт юм. Халзан бүрэгтэйн ордод 2000 онд хайгуулын тусгай зөвшөөрлийг 1997 оны ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу олгосон. Үүний дараа 2001 болон 2004 онуудад уг зөвшөөрөл өөрөөр хэлбэл тус хуулийн 18.6.1 дэх заалтын дагуу хайгуулаас ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжсэн. Одоогийн тусгай зөвшөөрөл эзэмшигч рүү 2011 онд Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 242, 243 тоот тушаалаар 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 49.1 дэх хэсгийн дагуу шилжүүлсэн.

6.Сонсголын үеэр төрийн байгууллага болон шинжээчийн гаргасан дүгнэлтээр тусгай зөвшөөрөл нь хуульд заасан шаардлагыг хангасан хууль ёсны бөгөөд хүчинтэй байна гэж.

7.Өмнөх жилүүдэд ордыг ашиглаагүй, хөрс хөндөгдөөгүй. Зөвхөн хайгуул судалгааны ажил хийж, нөөцийг нэмэгдүүлэх боловсруулалтын аргыг судлах үйл ажиллагаанууд явагдаж байна.

8.Малын эрүүл мэндийн талаар Мянгад сумд өмнөх онуудад төрсөн гажигтай төлүүдэд хийсэн Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн шинжилгээ, дүгнэлтээр цацрагийн хордлого илрээгүй, цацрагаас болсон гэдэг нь тогтоогдоогүй. Мянгад сумд 2025 оны хавар ургийн гажигтай төрсөн төлүүдэд цацрагийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэж, цацрагаас шалтгаалсан эсэхийг нь л баталгаажуулах шаардлагатай.

Учир нь Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн цацраг тоног төхөөрөмж эвдэрсний улмаас одоогоор цацрагийн шинжилгээ хийх боломжгүй байна.

9.Төрийн байгууллагын зүгээс танилцуулсан мэдээлэл болон шинжээчдийн дүгнэлтээр хайгуулын үйл ажиллагаа явагдаж байх үед байгалийн цацрагийн хэм хэмжээ хүрээлэн буй орчин, хүн малын эрүүл мэндэд хордлого үүсгэх тунгаас эрс бага байна.

10.Төсөл хэрэгжүүлэгч нь Халзан бүрэгтэйн ордын нөөцийн тооцоо, ТЭЗҮ байгаль орчны ерөнхий үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг боловсруулсан. Ордын ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг харьяа яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулж, иргэдээс санал авч баталгаажуулах шаардлагатай.

11.Хайгуулын шатад усны нөөц болон чанарт онц ноцтой хохирол учруулсан гэсэн шинжээчийн дүгнэлт болон төрийн байгууллагаас өгсөн мэдээллээр нотлогдоогүй. Гэхдээ ашиглалтад шилжих үеийн технологийн усны хэрэглээг эцэслэн тооцоолох, эх үүсвэрийг нь тодорхойлох, усны нөөц, чанарыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах зайлшгүй шаардлагатай.

12.Орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудаас төслийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдлуудыг төрийн байгууллагуудаас сонсголын явцад тодруулахад тухайн гомдлуудад дурдсан нөхцөл үндэслэл муутай нотлогдохгүй байсан.

13.Сонсгол оролцогчид гишүүдийн зүгээс газрын ховор элементтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг давхардуулан хуульчилсан нь ойлгомжгүй, сайжруулах шаардлагатай болохыг илэрхийлсэн.

14.Газрын ховор элементийн талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийн талаар харилцан ойлголцол, ойлголт муутай байна. Төрөөс олгосон тусгай зөвшөөрөл дээр үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

15.Орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгчийн хамтын ажиллагаа хангалтгүй. Хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа маш муу явуулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагууд санаачилга сул байна.

16.Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутгийн иргэдэд төслийн үйл ажиллагаа, үр ашиг, түүнээс тухайн орон нутагт шууд үзүүлэх үр ашиг, хүрээлэн буй орчинд үзүүлэх үр нөлөөг ойлгуулах талаар хангалтгүй ажилласан.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1.Монгол Улсын газрын ховор элемент хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг явуулах эрх зүйн орчин дахь тулгамдсан асуудал, хуулийн нийцлийг хангах, давхардлыг арилгах, газрын ховор элементийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах, гадаад хөрөнгө оруулалтыг татахад саад учруулж давхардал үүсгэж буй Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуулиудын

хийдлийг арилгаж, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг тодорхой болгох. Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

2.Монгол Улсад эрдэс баялгийн салбарт газрын ховор элементийн хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Халзан бүрэгтэйн ордод хийгдэж буй хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлж, нөөцийг бүрэн тогтоох, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухаанч байдлаар тодорхойлох зэргийг харьяа төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгч нар хариуцах.

3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, геологи хайгуулд гадаадын хөрөнгө оруулагчийн итгэлийг хамгаалах үүднээс хууль хяналтын байгууллагаас үйл ажиллагааг нь зогсоохоос бусад тохиолдолд хайгуул судалгааны ажлыг тасралтгүй явуулахад харьяа төрийн захиргааны байгууллагаас анхаарах шаардлагатай. Нөгөө талаас төслийн үйл ажиллагааны явц дахь байгаль орч орчны нөлөөллийг тасралтгүй хянах, иргэдийн санаа зовоосон асуудлуудад мэдээлэлтэй байх үүднээс харьяа төрийн захиргааны байгууллага, орон нутаг дахь хяналт шалгалтын эрх бүхий нэгжүүд тогтмол хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.

4.Төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн иргэд төрийн захиргааны байгууллагад мэргэжлийн эрдэмтдийн хамтарсан ажлын хэсэг байгуулж, төслийн талаар нэгдсэн мэдээлэл, ойлголттой болох, харилцан ойлголцлыг нэгтгэх үйл ажиллагааг санаачилж зохион байгуулах.

5.Хайгуул судалгааны ажил дууссаны дараа Халзан бүрэгтэйн ордын нөөцийн тооцоолол, ТЭЗҮ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ зэргийг харьяа яам, мэргэжлийн зөвлөлүүдээрээ хэлэлцүүлж, ордыг ашиглалтад бүрэн бэлтгэгдсэн эсэх, ашиглалтаас үүдэх экологи, эдийн засгийн болзошгүй хохирлын талаарх дүгнэлт гаргах шаардлагатай. Иймээс чиг үүргийн төрийн захиргааны төв байгууллагууд газрын ховор элемент дээр шинжлэх ухаанд суурилсан нарийвчилсан судалгаа шинжилгээтэй байх хангалттай мэдээлэлтэй байх шаардлагатай.

6.Халзан бүрэгтэйн ордоос Монгол Улсын урт хугацааны бодлогын бичиг баримт дээр 4.2.13-д заасан зорилтын хэрэгжилтийг хангах үүднээс тус ордын түүхий эдийг боловсруулахдаа баяжуулалт болон боловсруулалтын үйлдвэрийг ашиглан нэмүү өртөг шингээн эдийн засгийн тэлэлтийг дэмжих бүтээгдэхүүн гаргах.

7.Төрийн захиргааны төв байгууллагууд хоорондын ажлын уялдааг сайжруулах, нэгдсэн ойлголт мэдээлэлтэй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах.

8.Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс цацраг идэвхийн нөлөөлөл технологийн процесст ямар бүтээгдэхүүнд хэрхэн тархаж байгааг судлан холбогдох дүрэм журмыг баримтлан ажиллах.

9.Хүрээлэн буй орчин, ус, хөрс, хүн, малд цацрагийн шинжилгээ хийх чадавх хангалтгүй байгаа тул цацрагийн чиглэлээр нарийн мэргэжлийн хүний нөөц, лабораторийн тоног төхөөрөмжийг орон нутагт сайжруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Тайлан дууслаа.

Б.Жаргалан: 2025 оны 9 дүгээр сарын 23-нд зохион байгуулагдсан Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг танилцуулсан Улсын Их Хурлын гишүүн, тус сонсголыг даргалагч Баярмагнайн Баярбаатарт баярлалаа.

Гишүүд асуулт асуухаас өмнө ерөнхий хяналтын сонсголын үеэр бас шинжээчээр томилогдон ажилласан шинжээч нарын бүрэлдэхүүн танхимд хүрэлцэн ирсэн байна. Шинжээч нарыг танилцуулъя. Мишигдоржийн Пүрэв-Очир Ашимын Хаумдас, Наранбаатарын Уртнасан, Түмэндэлгэрийн Аззаяа, Нямсүрэнгийн Наранцэцэг, Эрдэнэболдын Цэрэнчимэг, Хузаабаярын Лхагвабаатар нарын шинжээч нар хүрэлцэн ирсэн байна. Гишүүд бас шинжээч нараас асуулт асуух боломжтой. Тэгэхээр тайлантай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Тусдаа. Гишүүд нэрээ өгье. Одонтуяа гишүүнээр гишүүдийн нэрсийг тасаллаа. Ирцээр нь эрэмбэлсэн байна. Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр маш чухал асуудлаар бас сонсгол хийжээ. Яагаад гэхээр өнөөдөр нэг талаасаа бүр бид чинь дэлхий дээр энэ ашигт малтмалынхаа энэ газрын ховор элементийн талаар маш том боломж байгаад байдаг. Гэтэл нөгөө талаар энэ төсөл нь ингээд хөдлөхгүй, гацчихсан байж байгаа. Тэгэхээр яг ийм цагаа олсон ийм сонсгол болжээ гэж бас хэлье. Энэ сонсголын материалтай танилцлаа. Энэ дүгнэлтүүдтэй ч ер нь танилцлаа. Тэгэхээр зүгээр нэг ийм юм ажиглагдаад байна. Би бас нэг юм асуух шаардлагатай байна.

Энэ манай төрийн байгууллага, хувийн хэвшил, орон нутгийн ажлын уялдаа гэж ерөөсөө огт байхгүйгээс энэ маш том хүндрэлүүд үүсээд байна л даа. Эрдэс баялгийн салбар төрөөс баримтлах бодлого гэж бас ахалж ажиллаад батлуулж байхад 1 заалт оруулсан нь юу вэ гэхээр нэгэнтээ төрийн байгууллага зөвшөөрөл өгсөн л бол үүнийхээ араасаа явдаг байх хэрэгтэй. Тэр хувийн хэвшилтэйгээ очоод тэр орон нутагт нь ажиллаад энэ сэдвийг нь ойлгуулаад ингэхгүйгээр өнөөдөр зүгээр нэг бичиг өгөөд л хаячихдаг. Нөгөөдүүл нь очоод тэнд ерөөсөө яг эзэнгүй хүмүүс шиг л ингээд маш хүнд байдалд байгаа шүү дээ. Тэгэхээр энийг яаралтай бид нар энэ хууль, эрх зүйн орчныг нь дүрэм журмыг сайжруулах ёстой. 1 дүгээрт.

2 дугаарт энэ орон нутагт нь энэ төсөл хэрэгжсэнээс ийм ийм ач холбогдолтой зүйл гарах юм гэдгийг өнөөдрийн байдлаар бид нар бас нарийн яг ингээд орон нутагт нь өгөөд, орон нутаг нь хөгжчихсөн юм байхгүй учраас иргэд бас эсэргүүцээд байгаа байхгүй юу. Тэр иргэдэд бол үнэхээр тэр дэлхийн зах зээл дээр энэ мундаг өндөр байна уу, улс орны эдийн засаг чухал байна уу. Хамаагүй. Бид нар чинь энд амьдарч байгаа хүмүүс. Ингээд бид нарт юу оногдох юм бэ гэдэг энэ 2 асуудлыг бол бид нар зайлшгүй ер нь энэ Улсын Их Хурлын гишүүд шийдэж байж ер нь манай энэ бүх ашигт малтмалын төслүүд бол явна гэж хардаг.

Би нэг юм асуух гэсэн юм. Байгаль орчны яаманд байхдаа олон улсын хөндлөнгийн шинжээчдийг ажиллуулъя. Манайд бол бас нарийн мэргэжлийн хүмүүс зарим нь бол байхгүй байх. Тэгэхээр энэ олон улсын шинжээчдийг ажиллуулаач ээ гэж бас төсөл хэрэгжүүлэгч газарт хандаад, төсөл хэрэгжүүлэгч газар энийг бас хийгээд эхэлсэн байх ёстой. ТЭЗҮ-үүдийг яаралтай дуусгах ёстой. Тэр ТЭЗҮ-ээр бол бүх юм гарах ёстой. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байгаль орчинд ямар

нөлөө үзүүлэх юм гэдэг юм чинь энэ ТЭЗҮ-ээр нарийвчилж гарах ёстой. Тэгэхээр энэ ТЭЗҮ-үүд гарсан уу. Энэ ТЭЗҮ чинь ямар байдалтай байгаа юм бэ гэдэг ийм 2 асуулт байна. Тэгээд ер нь бол одоо бид энэ дэлхий дээр өнөөдөр газрын ховор элементтэй улс орнууд л маш том тоглогч болж байна шүү дээ. Өмнө нь бол юу гэдэг юм. Гангийнх, газрын тос гээд .../минут дуусав/

Б.Жаргалан: Энэ хууль, эрх зүйн орчны уялдаа холбоотой асуудлаар Баярбаатар дарга хариулаад, тэгээд энэ ТЭЗҮ-тэй холбоотой асуудлаар Уул уурхайн яамнаас төлөөлөл хариултаа бэлтгэж байна уу. Баярбаатар гишүүний микрофоныг.

Б.Баярбаатар: Одонтуяа гишүүнд баярлалаа. Бас чухал асуудлыг хөндлөө. Байгаль орчны сайдаар бас ажиллаж байсан хүний хувьд. Ер нь энэ төр бол энэ тусгай зөвшөөрөл өгсөн бол үүнийхээ ардаас бас тодорхой түвшинд үйл ажиллагааг нь явуулахад дэмжлэг үзүүлдэг, тодорхой хугацаа, хүрээ хязгаарт бас хамгаалалт хийдэг байх ёстой. Өнгөрсөн хугацаанд яг энэ газрын ховор элементтэй холбоотой энэ Халзан бүрэгтэйн орд энэ Ар хүрэн гэж уул байгаа юм. Яг Халзан бүрэгтэйн хойд талынх нь уул. Тэгээд энэ нөөцөө тогтоох гээд өрөм хатгаад ингээд төсөл хэрэгжүүлэгч бол ажилласан. Орон нутаг бол энэ дээр нэг их айхтар дэмжлэг үзүүлж ажиллаж чадаагүй. Орон нутгийн удирдлагуудтай холбогдох мэдээ мэдээллийг солилцоход бол нэлээн хангалтгүй мэдээллүүдийг бол өгч байсан байгаа юм. Тэгээд орон нутгийн иргэдтэй ойлголцолд хүрэх процессууд их муу явагдсан учраас төсөл хэрэгжүүлэгчид бол өнгөрсөн хугацаанд үргүй зардлуудыг бол нэлээн гаргасан.

Ер нь бол Ховд аймгийн хэмжээндээ бол Хөшөөтийн уурхай гээд том уурхай үйл ажиллагаа явуулж байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын бүтээн байгуулалтын ажил явж байгаа. Одоо энэ газрын ховор элементийн асуудал ороод ирвэл зөвхөн Хөшөөтийн уурхай гэхэд л өөрөө аймгийн ДНБ-ий 40-өөс дээш хувийг хангаж байдаг. Тэгэхээр саяын дурдсан бүтээн байгуулалтууд нэмэгдээд ороод ирвэл бол Ховд аймгийн бүтээн байгуулалтад бол өөрөө их өндөр хувь нэмэр оруулах ийм ач тус байгаа юм гэдгийг бас харж байгаа. Хууль, эрх зүйн орчныг бол зайлшгүй сайжруулах ёстой. Ашиг малтмалын хууль, Цөмийн энергийн хууль 2-ын зүйл заалт нь бол хоорондоо зөрчилдчихсэн учраас цаашаа энэ яг олборлолтын өмнө шатанд бол хууль, эрх зүйн орчныг нэлээн боловсронгуй болгоод, тухайн сум, орон нутгийн иргэдийн хүртэх өгөөжийн асуудлыг ер нь болж өгвөл хуульчлахгүй бол нөгөө ард иргэдийн маань бас буруу биш байгаад байгаа юм. Тодорхой түвшинд амлалт өгөөд, дараа нь амлалтаа хэрэгжүүлэхгүй алга болсоор байгаад нөгөө иргэд маань өөрсдөө энд бухимдаад, уурлаад байгаа тал бас байгаа нь зөв байгаад байгаа юм.

Б.Жаргалан: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төлөөлөл. Хэдэн номер вэ. 4 номерын микрофоныг өгье. Өөрийгөө танилцуулаад асуултад хариулна уу.

Х.Лхагвабаатар: Сайн байцгаана уу. Бид хэд шинжээч болохоор яг нөгөө байгууллагаа төлөөлж биш, шинжилгээ хийснээрээ л танилцуулж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Лхагвабаатар шинжээчээр ажилласан. Халзан бүрэгтэй ордын техник, эдийн засгийн боловсруулсан байдал гээд. Анх ТЭЗҮ-ийг бол 2018 онд боловсруулаад, тухайн үеийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлээд, хүлээлгэж өгсөн байдаг. Үүний дараа 2023 онд дахин ТЭЗҮ-ийг нь тодотгоод, тэгээд бас Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Яг энэ төслийн хувьд бол ийм 2 ТЭЗҮ бол ингээд боловсруулсан байгаа.

Б.Жаргалан: Одонтуяа гишүүн тодруулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр тэр олон улсын шинжээчдийн баг ажиллаж байгаа талаар тэгвэл би дараа нь тэр төсөл хэрэгжүүлэгчээс мэдээлэл авъя. Ер нь зүгээр яах вэ дүгнээд хэлэхэд энэ газрын ховор элемент гэдэг бол өнөөдөр бид нарт бас их алтан боломж байгаа. Тэгэхээр би бол энэ асуудлыг төр засаг бүр яг хариуцаад, энэ чинь төсөв бүрдүүлэх бас хамгийн чухал хэрэгсэл, эх үүсвэр гэж үзээд энэ дээр бүр маш сайн ажиллах ёстой. Нүүрс ч гэсэн хортойгоо хүрвэл хортой шүү дээ. Тэр байгаль орчныг бол нийтэд нь будаа болгож л байгаа шүү дээ. Тэр дээр тэгээд хэтэрхий хямд үнэтэй тэр бүхэл бүтэн нутгаар нь айхтар болгочихсон байж байгаа. Гэтэл энэ газрын ховор элемент чинь өөрөө үнэ өртгийн хувьд шал өөр өндөр өртөгтэй. Тэгэхээр бид нар энэ дээр нь дэлхий ертөнц чинь хөгжлийн өндөр түвшинд хиймэл оюун ухаан хөгжихсөн үед яг тэр .../минут дуусав/

Б.Жаргалан: Гүйцээгээд тодруулга авъя. Одонтуяа гишүүний микрофон.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ газрын ховор элементийг бид явуулдгаар нь явуулаад, байгаль орчны бүх тэр нарийвчилсан үнэлгээнүүдийг нь гаргаад, энэ үнэлгээ дээрээ үндэслээд энэ байгаль орчны нөхөн сэргээлт бүх тэр аюул осол сая уран дээр бас зөндөө л ажиллалаа шүү дээ. Бүх л юмыг хэмжилт хийж болж байна. Энэ чинь нарийн лабораториуд гарчихсан байна. Тоног төхөөрөмжүүдээр хангаж болж байна. Тэгээд эндээс тэр орон нутагт нь өгөөжийг нь өгөөд ингээд нэг төсөл хэрэгжүүлэхгүй бол би 2012 онд анх гишүүн болоод орж ирэхэд л нэг ийм юм л яригддаг байсан. Тэгээд л тэр эрдэс баялгийн бодлогод оруулсан хэвээрээ л байж байя. Ерөөсөө орон нутаг нь төр засагтайгаа учраа олдоггүй, хөрөнгө оруулагчтай ингэхээр чинь яаж манай улсад хөрөнгө оруулагчид орж ирэх юм бэ. Тэгэхээр энэ дээр бол зүгээр байгалиа ч хамгаалах хэрэгтэй, эндээс үр өгөөжийг нь бол яаралтай хүртэх хэрэгтэй л гэж үзэж байна.

Б.Жаргалан: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүний микрофон.

Л.Мөнхбаясгалан: Халзан бүрэгтэйн төслийг хэрэгжүүлснээр Монгол Улс их хэмжээний ашиг олно. Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлнэ гээд байгаа юм. Тийм ч биз. Гэхдээ энэ сонсгол дээр бол би өмнө нь яг бүтэн сонссон. Сонсгол учраас сонссон. Экологи, эдийн засгийн үнэлгээ хийгдээгүй байгаа. Эдийн засгийн ач холбогдлыг нь ойлгуулаад байгаа юм. Экологийн ямар алдагдалд орох юм. Дараа нь бид нар экологио нөхөн сэргээх гэж хэчнээн доллар дэлхийгээс гуйх юм бэ. Энэ төсөл дээр байгаль орчны менежментийн төлөвлөгөө гарсан. Нарийвчилсан үнэлгээ гарсан. ТЭЗҮ нь бэлэн болсон. Тэгсэн хэр нь экологи, эдийн засгийн үнэлгээ нь хийгдээгүй.

Дээрээс нь усны нөөц нь тодорхойгүй. Халзан бүрэгтэйн төсөл хэрэгжихэд 300 литр секунд ус хэрэгтэй гэж байгаа юм. Одоогийн тогтоосноор 9 литр секунд 2-хон худагтай. Хар ус нуураас 17км зайд Ховд голоос 12км зайд гэж байгаа юм. Лицензийн талбайг оруулаад бодоод үзэхээр 5км зай гэж ингээд дахиад нэг юу хэлээд байгаа байхгүй юу. Талбай хэлээд байгаа юм. Ховд гол бол манай Монгол улсын эко системийн амин судас нь. Хүнээр бол артерийн судас нь байхгүй юу.

Тэгэхээр бид нар Ховд голыг хамгаалах ёстой. Энийг олон улсын донор байгууллагууд, экосистемийг дэмждэг, нөхөн сэргээлт хийдэг олон улсын байгууллагууд Ховд голыг тасалж болохгүй шүү гэдэг байр суурь баримталдаг. Гэтэл энэ Ховд голын яг хаяа дээр нь усны нөөц нь тодорхойгүй ийм төсөл хэрэгжих гээд байгаа юм.

Би зүгээр ингэж бодож байна. Би бол усны нөөцгүй болсон говийн бүсийн гишүүн. Бид нар говьд өнөөдөр гадаргын ус татах гэж, бид өнөөдөр уул уурхайдаа зориулсан газрын гүний усаа яаж гадаргын усаар нөхөх вэ, яаж трубагаар ус татах вэ гэдэг дээр шаналаад маш их ажиллагаа хийж байгаа. Бид нар гаднын байгууллагуудаас мөнгө гуйж байгаа. Хөв цөөрөм барья эд нар гээд. Гэтэл өнөөдөр баруун монголчууд энэ дээрээ санаа зовж байгаа нь зөв шүү дээ. Би бол Ховдын гишүүдэд хандаж хэлмээр байгаа юм. Бид нар, би бол усгүй газрын гишүүн. Усгүй байхын зовлонг мэднэ. Эко систем яаж алдагддагийн зовлонг мэднэ. Уур амьсгалын өөрчлөлтөд яаж өртөж байгаа, яаж эхнээсээ нүүлгэн шилжүүлэлтэд өртөж байгаа вэ гэдгийг газар дээр нь биеэр туулсан бүсийн гишүүн байхгүй юу.

Тэгэхээр манай Ховдын гишүүд энийгээ сайн бодож, энэ эдийн засаг, эко системийн үнэлгээг заавал хийх ёстой. Энэ дээр усны нөөцөө тогтоогоогүй байна гээд сонсголын дүн дээр биччихсэн байна шүү дээ. Дүгнэлт дээр. Усны хэрэглээг эцэслэн тооцоолох, эх үүсвэрийг тодорхойлох, усны нөөц чанарыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах зайлшгүй шаардлагатай. Мөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг харьяа яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулах ёстой. Ийм байхад бид нар яаран сандран энэ төсөл үнэхээр үнэтэй төсөл гэж бас давхимааргүй байгаа юм.

Б.Жаргалан: Баярбаатар дарга хариулъя. Тэгээд тэгээд дараа нь тодруулах уу Мөнхбаясгалан гишүүн.

Б.Баярбаатар: Мөнхбаясгалан гишүүнтэй яг санал нэг байгаа. Тайланд бас яг энэ асуудлаар бол тусгагдсан. Ер нь гол асуудал бол энэ усны асуудал их чухал байгаа юм. Тэгээд энэ экологийн үнэлгээ бол хийгдээгүй байгаа. Энийг хийгдэж зайлшгүй иргэдэд би бас энэ тайландаа тусгачихсан байж байгаа. Иргэдэд бүр танилцуулж, батлуул гэж байгаа юм. Иргэдэд танилцуулж батлуулах зайлшгүй. Ер нь бол том юуг нь үзэх юм бол энэ өнөөдөр нөөц тогтоох шатандаа явж байгаа асуудал. Ашиглалтын асуудал бол дараагийн асуудал орж ирэх юм. Магадгүй ашиглахгүй ч байж магадгүй гэж үзэж байгаа. 2 боловсруулах үйлдвэр барих ёстой юм байна лээ. Боловсруулаагүй зүгээр ачааны машин дээр зөөгөөд гаргавал 1 тонн нь 650 доллар, 2 шатын үйлдвэрээр дунд хүртэл нь боловсруулаад гаргахад 1кг нь 62 доллар болж хувирч байгаа. Тэгэхээр эдийн засгийн үр өгөөж нь бол энэ дээр таны хэлж байгаа бол үнэн. Гол нь нөгөө байгаль орчинд үүсэх хор уршгийг нь бид нар бол маш сайн нарийвчилж судалж, эрсдэлийг тооцож байж, үүний дараа ашиглалтын асуудал ярих ёстой. Одоо бол нөөц бол ийм байна. Нөөцөө өшөө нэмэгдэх боломж нь ийм байна, нөөц нь нийт тэдэн жилийн хугацаатай ийм ашиглалтаар ингэж явна гэдэг юмаа л гаргах шатдаа явж байгаа гэж ойлгож болно.

Б.Жаргалан: Мөнхбаясгалан гишүүний асуулттай холбоотой байгаль орчны үнэлгээ бөгөөд энэ усны асуудалтай холбоотой шинжээч нараас хариулт өгөх хүн байна уу. Тэгвэл гараа өргөөд үг авбал. Байхгүй юу. Мөнхбаясгалан гишүүн тодруулах уу. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Тэгэхээр усаа яаж хүргэх талаар, усны нөөц, экосистемийн алдагдалд хэчнээн доллар бид алдах вэ. Дараа нь тэрийгээ нөхөн сэргээхэд яах вэ гэдэг дээр хариулт байхгүй байна. Тэгэхээр Баярбаатар гишүүний хэлж байгаагаар усны нөөцөө сайн тогтоох хэрэгтэй. Эко систем яаж алдагдах гэдгийг нарийвчлан тогтоох ёстой. Сая бид нар нэлээд олон яамны өргөтгөсөн бүрэлдэхүүн Хятадад очоод ирсэн. Анх хуа мужаар орсон. Тэнд 5 жилийн турш 1 нуурыг нөхөн сэргээж

байна. 400 сая доллар гарчхаад, дахиад 250 сая доллар хэрэгтэй гэж байна. Усны шувууд ирдэг байснаа ирэхээ больсон. Тэр усны шувууг буцааж тэнд авчрахын тулд маш их мөнгө, хөрөнгө зарцуулж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ чинь их мундаг, ёстой үнэхээр хэрэгтэй төсөл, их үнэтэй төсөл гэж давхичхаад, дахин нөхөн сэргээдэг эко системээ битгий алдаасай л гэж бодож байгаа. Говийн бүсэд бол эко систем бүрэн алдагдсан. Тэгэхээр говийн гишүүний хувьд устай газрын усыг .../минут дуусав/

Б.Жаргалан: Мөнхбаясгалан гишүүнд баярлалаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Бид нар яг энэ нөгөө уул уурхайн асуудал дээр бүгдээрээ нийтээрээ 2 талцаад байна л даа. Эсвэл уул уурхайгаа ашиглана. Эсвэл уул уурхайгаа ашиглахгүй. Гэхдээ эдийн засаг мөнгөтэй байх ёстой. Хаанаас вэ. Уул уурхайгаас гээд. Гуравдагч тал буюу дундын хувилбар энэ бүхнийг зохицуулж ирэх боломжтой тэр бодлогын асуудлууд дээрээ хэдүүлээ илүү төвлөрч ажиллах ёстой болов уу гэж би хувьдаа тийм байр суурьтай байдаг. Уул уурхайг ашиглахгүй гээд эсэргүүцсэн нутгийн иргэдийг болохоор бүгдээрээ цахим орчинд бүгдээрээ ингээд л орк, янз бүрийн байдлаар ингээд дуудаад, нэр хоч өгөөд л явдаг. Энэ чинь ялгаа байхгүй. Ингээд 2 талцаад л шийдэл ерөөсөө энэ дундаас гарахгүй байхгүй юу.

Тэгэхээр ялангуяа ингээд нөгөө хамтарсан Байнгын хороод хуралдаж байгаа яг энэ тохиолдолд дундын шийдэл, дундын хувилбар, бодлогын хувилбар гэдэг дээрээ илүү төвлөрвөл зүгээр болов уу гэж бодож байна. Би сая энэ санал, дүгнэлтийг нь төгсгөл буюу яг цаашид авах арга хэмжээ гэдэг дээр нэг асуулт байгаад байгаа юм. Ялангуяа энэ төслийн хувьд болоод өөр бусад төслийн хувьд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, тухайн нутгийн иргэдэд үзүүлж байгаа энэ нөлөөллийг цаашид урт хугацаандаа бодлогын түвшиндээ энэ нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах ямар стратеги, бодлогыг яг энэ төсөл дээр жишээ нь барьж байгаа юм бол. Одоо мэдээлэл юмнууд яг энэ дотор хэр авагдав. Байхгүй байгаа юу. Байгаа юу. Байгаа бол яг түүнийг нь нутгийн иргэд хүлээн зөвшөөрч байгаа юм уу. Хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол гол асуудал нь юун дээр иргэд ингээд ойлголцохгүй дургүйцээд байгаа гэдэг дээр цаашид бодлогын хувьд яах ёстой вэ гэдэг ийм шийдэл байгаа юу гэдэг ийм асуулт.

2-т нь төр зөвшөөрөл өгсөн гээд хувийн хэвшлээ шууд иргэнтэй нүүр тулуулдаг энэ байдлыг л болиулах хэрэгтэй. Төр өөрөө яах гэж байгаа юм. Төр өөрөө дунд нь цэвэр зохицуулалт хийх үүрэгтэй гэсэн үг. Тэгэхээр төрийн зохицуулалтыг бид нар энэ дээр аягүй оновчтой харах, ялангуяа байгаль орчны нөлөөллийн үнэлгээ дотор энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээ өөрөө маш жижигхэн хэсэг болоод яваад байгаа юм. Гэтэл яг энэ ганц хоёрхон энэ заалт маань өөрөө хамгийн том яг энэ ашиглалт дээр очоод, уул уурхай дээр очоод хамгийн нүүр тулж байгаа асуудал л даа. Тэгэхээр энэ дээр зохицуулалтын хувьд, бодлогын хувьд цаашид анхаарах ямар бодлогын өөрчлөлтийг харж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Б.Жаргалан: Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Баасанжаргал гишүүнтэй бас санал нэг байна. Ер нь гол буруутан нь тэгээд л төр болчихоод байгаа юм. Тусгай зөвшөөрлөө өгчихдөг. Тэгээд бодлогын бичиг баримт дээр товчхон өгүүлбэр оруулаад баталчихдаг. Тэгээд тэр нь цаашаагаа явдаггүй. Тэгээд 1 төсөл хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтаа татаад,

тэндээ үйл ажиллагаагаа эрхлэх гээд байдаг. Иргэдийн бас зөрүүтэй ойлголтоос болж эсэргүүцэлтэй тулдаг. Тэгээд энийгээ бас ойлголцчих гээд аль аль тал нь ингээд үздэг. Дунд нь орон нутгийн удирдлагууд нь орж ирж бас ойлголцолд хүрэх гээд үздэг. Тэгээд 1 дүгээрт цаг хугацаа, 2 дугаарт үр ашиггүй зардал гараад байгаа юм. Тэгээд энийг бол ер нь сонсгол дээр хаахад ч би өөрөө санал гаргаад хэлчихсэн. Ер нь би түрүүн ч бас хэллээ. Энэ иргэдэд яг хуульчлах ёстой л гээд байгаа юм. Нөгөө өгөөжийг нь, хүртэх өгөөжийг нь хуульчлах ёстой. Одоо жишээлбэл Дорнод аймгийн манай Бадамсүрэн гишүүн байхгүй байх шиг байна. Дорнод аймгийн Матад сумын иргэд бол яг энэ дээр хохирогч болоод үлдчихсэн иргэд байж байгаа. 20 жилийн өмнө тэр нефть боловсруулалт, нефтийг нь зөөгөөд явахдаа баахан амлалт өгчихсөн. Нөгөө амлалт нь хэрэгжээгүй. Өнөөдөр тэр Матад сумын цэцэрлэг нь нурах гээд байж байгаа байхгүй юу. Тэгээд цэцэрлэг барьж баригдчихсан чинь одоо тэгээд тэгэхээр ийм муу жишиг цаашаа энэ орон нутгуудад бий болохгүй байх ёстой гэдэг үүднээс энийг хуульчлах ёстой. Дээр нь иргэдэд их зөв ойлголтыг л өгөх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Ямар нэгэн байдлаар жишээлбэл иргэдэд очоод энэ бол ингээд уран юм гээд буруу ойлголтыг өгөөд, нөгөөдхөд нь иргэд бас итгээд цаашаа явдаг. Ингээд төсөл хэрэгжүүлэгч болон иргэдийн дунд ингээд үл ойлголцол хурц шатандаа үүсээд, заримдаа тэмцэл хэлбэр хүртэл шилжээд, хүний эрх зөрчигдөх байдал руу хүртэл ингээд орсон ийм үр дүнгүүд бол муу үр дүнгүүд бол өнгөрсөн хугацаанд гарсан юм. Тэгэхээр энэ дээр бас төр өөрөө тодорхой бодлого гаргаж, аль аль тал нь иргэдийнхээ эрх ашгийг 1 дүгээрт тавьдаг байх ёстой.

2 дугаарт хөрөнгө оруулагчийнхаа эрх ашгийг тавьж энэ асуудалдаа хандах ийм бодлогыг гаргах зайлшгүй шаардлага байгаа. Санал нэг байна. Баярлалаа.

Б.Жаргалан: Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Халзан бүрэгтэйн ордтой холбоотой мэдээллийг бид үзлээ. Тэгээд энэ Халзан бүрэгтэй ордын асуудал бол ганц ордын асуудал биш. Монгол Улсад цаашдаа илэрч олдох ховор элементүүд болон байгалийн баялагтай холбоотой асуудлууд дээр гарч ирж байгаа л үзэгдэл л дээ. Тэгээд үүнтэй холбоотойгоор маш их маргаан гарлаа. Нэг хэсэг нь үүнийг ухаад маш муу үр дүнгүүд гарах гэж байгаа талаар ярьж, тэр байтугай хөрөнгө оруулагчдаа хөөж, тууж, тэнд байсан кемпийг нь нурааж ийм үйлдэл гарсан. Тэгээд үүний цаана юу байна вэ гэхээр нийтийг хамарсан мэдлэггүйжилт, боловсролын ойлголт муу байгаа байдал. Ялангуяа байгалийн шинжлэх ухаан энэ металлургийн боловсролгүй байдал нөлөө үзүүлж байгаа гэж бодож байгаа. Тэгээд энэ ажлыг ер нь хэр хийх ёстой гэж шинжээч нар маань үзэж байгаа юм. Ажлын хэсэг энэ дээр ярьж үзсэн үү. 1 дүгээрт.

2 дугаарт эрх зүйн зохицуулалтыг давхардуулан хуульчилсан нь ойлгомжгүй байна гэж байна. Энэ дээр шинжилгээ хийж үзэв үү. Ямар ямар хуулиуд ямар байдлаар давхардаад эсвэл ойлгомжгүй болоод сайжруулах ёстой гэж үзэж байгаа вэ. Энэ дээр саналууд бодитой байна уу.

3 дахь нь газрын ховор элементийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийн талаар харилцан ойлголцол муутай байна гэж байна. Энийг яая гэж та бүхэн санал гаргаж байгаа вэ. Газрын ховор элементийн талаар маш ойлголтгүй байгаа гэдэг нь ойлгомжтой байгаад байгаа шүү дээ. Уран ухах гэж байгаа юм шиг, Тори ухах гэж байгаа юм шиг байдалтай иргэд олон нийт маань ойлгоод яваад байдаг. Энийг яаж шийдэх вэ.

Дараагийн асуулт 4 дэх асуулт нь орон нутгийн иргэд, нутгийн захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгчийн хамтын ажиллагаа хангалтгүй байна гэж байна. Үүнийг яаж хууль, эрх зүйн болон практик байдлын хэмжээнд сайн болгох вэ. Энэ дээр сайн загварууд байдаг юм уу. Үүнийг ажлын хэсэг хэрхэн сайн болгоё гэж үзсэн бэ.

5 дахь асуулт нь энд салбарын яам мэргэжлийн байгууллага нь хэрхэн дүн тавьж байгаа вэ. Тэдний байр суурь юу байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

Б.Жаргалан: Баярбаатар гишүүн хариулъя.

Б.Баярбаатар: Иргэдийн ойлголт сул, муу байгаа гэдэгтэй бол санал нэг байна. Тэгээд энэ дээр ямар нэгэн байдлаар өнгөрсөн хугацаанд яг ийм зургаар ингэж иргэдэд зөв ойлголт өгнө гэсэн ийм технологиор ерөөсөө ажиллаагүй. Үндсэндээ бол төсөл хэрэгжүүлэгч л иргэдэд ойлголт өгөх гээд л баахан явсан. Орон нутаг ч нэг их айхтар энэ дээр дэмжлэг үзүүлж яваагүй. Төр өөрөө энэ дээр нэг их дэмжлэг үзүүлж яваагүй юм байна лээ. Тэгээд энийг яг нэг тийм зөв ойлголттой, тэр ойлголцлыг нь түвшинд хүргэх ёстой гэдэг зүйл дээр бол сонсгол дээр бол өндөр түвшинд яригдсан. Батсүмбэрэл гишүүний ярьдаг.

Хууль дээр их тодорхой байгаа. Ерөөсөө Цөмийн энергийн хуулиар явах юм уу. Эсвэл Ашигт малтмалын хуулиар явах юм уу. Өнөөдөр ингээд яг харахаар хоёуланд нь хамаарах гээд байгаа ч юм шиг, эсвэл цөмийн энергиэр нь. Энэ нэг юуг нь төр, Улсын Их Хурал парламент өөрөө энэ эргэлзээг нь гаргаж өгөхгүй бол хэрвээ Цөмийн энергийн хуулиар явна гэх юм бол энэ ураны асуудал руу. Ашигт малтмалын хуулиар явна гэх юм бол ердийн ашигт малтмалын байдлаар. Цаашлаад нөгөө гарах ТЭЗҮ хамаг зүйлүүд нь эндээсээ шалтгаалаад шал өөр болчихоод байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас нэг хууль, эрх зүйн хувьд ойлгомжтой байгаа. Газрын ховор элемент ерөөсөө түүхэндээ анх удаа олборлож байгаа. Нөөц тогтоож байгаа манайх. Нийтдээ Монгол улсын хэмжээнд 6 орд байгаа. Ганц гайгүй боломжтой нь энэ Халзан бүрэгтэй. Увсад 1 байна. Өмнөговьд 1 байна. Хэнтийд 1 байна. Нөөцөө л тогтоож эхэлж байна. Эдгээрийг ер нь бас хууль, эрх зүйн орчин тэд нар нь бас гацаанд орчихсон юм байна лээ. Тэгэхээр эд нарыг нь ингээд бүгдийг нь арилгаж байгаад ер нь Монгол Улс ганцхан Ховд аймаг гэлтгүйгээр ер нь Монгол Улсын хэмжээнд газрын ховрынхоо нөөц юуг тогтоогоод нэг ёсондоо геополитикийн хувьд бол Монгол Улсын хувьд бол бас нэг томоохон боломж, хөзөр болж харагдаад л байгаа юм л даа. Гол нь бид нар энэ дотоодынхоо ойлголцлыг арилгаж чадахгүй байж гаднын хөрөнгө оруулалт татна гэдэг маань өөрөө эргэлзээтэй нөхцөл байдал орчихоод байгаа учраас сонсголын гол агуулга бас гаднын хөрөнгө оруулалт руугаа, дотоодын ойлголт руугаа нэлээдгүй чиглэсэн.

Орон нутгийн иргэдэд бол тэр дундын сан гэдэг зүйлийг төсөл хэрэгжүүлэгчээс байгуулаад, тэр сангийн Удирдах зөвлөлд ТУЗ нь байдаг юм уу тухайн сум орон нутгаасаа байгаад, тэндээсээ төсөл хэрэгжүүлэгч тодорхой төсвийг тэнд нь төвлөрүүлж байдаг. Тэрүүгээр нь орон нутгийн иргэд нь өөрөө шийдвэр гаргаад, хэрхэн юундаа зарцуулдаг ийм байдлаар явах ийм боломжийг хүртэл бид нар бас давхар давхар яриад явж байгаа. Энэ нь өөрөө ч бас иргэддээ үр өгөөжтэй, тодорхой түвшинд тухайн орон нутгийн иргэд нь хөрөнгө оруулалтынхаа асуудлыг өөрсдөө шийддэг байх ёстой гэдэг ийм зүйлээр бол асуудалдаа хандаад явж байгаа.

Сүүлийн асуултад Дамдинням сайд хариулах байх л гэж бодож байна. Яг салбар яам нь өөрөө энэ дээр яг ямар бодлого гарч байгаа юм гэдгийг нь бол танд Дамдинням сайд дараа нь хариулах байх. Баярлалаа.

Б.Жаргалан: Батсүмбэрэл гишүүн тодруулъя. Манай шинжээч нараас Батсүмбэрэл гишүүний асуултад тусгайлан хариулах хүмүүс байх юм бол гараа өргөөд хариултаа өгч болно шүү. Батсүмбэрэл гишүүн тэгвэл тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Яах вэ ер нь энэ миний хараад байгаагаар нийтийн мэдлэг олгох ийм чухал асуудал байгаад байх шиг байгаа юм. Шинжээч нар бас энийг сайн анзаарсан байх гэж би бодож байгаа. Өмнө нь бид нар ураны хэлэлцээрийн асуудал, гэрээний асуудал ярьсан. Энэ Туваан гишүүн хажууд байж байна. Сайд байсан. Ямар тийм мэдлэггүй, дорой буурай байна гэдгийг бид нар харсан шүү дээ. Тэгэхээр энэ эрдэм мэдлэгжүүлэх, нийтийг боловсруулах ажил дээр ялангуяа эрдэс баялгийн салбарын ойлголтыг энгийн болгож иргэдэд өгөх асуудал орхигдоод байгаа. Үүнийг салбарын яам, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид маань хийх хэрэгтэй байгаа. Энийг бас биечлэн мэдэрсэн энэ сонсгол зохион байгуулсан ажлын хэсэг бас анхаарч ажиллах хэрэгтэй байх гэж бодож байгаа. Тэгээд энэ Байнгын хороодын хамтарсан хурлын дүгнэлт дээр ч энэ орох хэрэгтэй байгаад байгаа юм. Энийг л би тодруулж асуумаар байгаа юм. Энэ дээр мэргэжлийн хүмүүс юу бодож байна. Хоосон харанхуйн дундуур яаж энийг ойлгуулах вэ.

Б.Жаргалан: 8 номерын микрофоныг нээе. Өөрийгөө танилцуулаад, асуултад хариулна уу.

Н.Наранцэцэг: Сайн байцгаана уу. Байгаль орчин нийгмийн нөлөөллийн асуудлыг хариуцаж байгаа шинжээч Наранцэцэг байна. Энэ төслийн хувьд болохоороо түрүүн Одонтуяа сайдын асууснаар бол 2024 онд гадаадын мэргэжлийн байгууллагатай хамтраад энэ төлөв байдлын судалгааг нэлээн дэлгэрэнгүй байдлаар олон улсын стандартад нийцүүлээд хийчихсэн. ТЭЗҮ-ийг мөн олон улсын стандартын дагуу 43.101-ээр хийгээд Монгол хувилбар луу батлуулаагүй байгаа ч гэсэн хийгдчихсэн байгаад байгаа.

Нийгмийн мэдээллийн хувьд болохоороо энэ орд маань өөрөө хайгуулын шатад явж байгаа орд, энэ хайгуулын шатын үе шат маань маш олон бэлтгэл ажлуудыг хийх үе шат байгаа. Түрүүн техник, эдийн засгийн үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ батлагдсан байна гэж хэлж байна. Энэ нь бол бэлтгэл ажлын шатад буюу хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор батлагдсан. Хангалттай эцсийн хувилбар бол гарч амжаагүй байгаа. Одоо энэ хайгуулын нарийвчилсан хайгуулаар бол ордын нарийвчилсан мэдээллүүд гарч ирснээрээ энэ төсөл маань өөрөө нэлээн нарийвчилсан .../минут дуусав/

Б.Жаргалан: Нэмж хариулт өгье. 8 номер.

Н.Наранцэцэг: Одоо оновчтой мэдээллүүд үнэн зөв гарч ирэх гэж байгаа. ТЭЗҮ дээрээ, нарийвчилсан үнэлгээ дээрээ буюу нөгөө экологи, эдийн засгийн үнэлгээ эцсийн хувилбар нь энэ ажлын дараа гарч ирэх учраас хүлээгдээд байгаа. Тэгээд мэдээллийг зөв болгож байж нөлөөлөлд усны хэрэглээ болон бусад нөлөөллийн мэдээллийг зөв болгож байж иргэдэд мэдээлэл хүргэх гэхээр мэдээллийн нөгөө эцсийн хувилбар гараагүй байгаа учраас хангалттай яг үнэн зөв мэдээлэл очихгүй байгаа гэж энэ төслөөс бол харагдаж байгаа.

Төсөл хэрэгжүүлэгч яг ямар менежмент баримтлах вэ гэхээр малчин иргэд буюу нөлөөллийн бүсэд байгаа багийн иргэдэд тулж очоод ингээд ганцаарчилсан асуулга авч нөгөө суурь мэдээллүүдийг өөрсдөдөө бас бэлдэх хэрэгтэй. Нийгмийн судалгаанууд бол 2024 онд хийгдсэн. ОУБ-тай хамтраад Монгол мэргэжилтнүүд хийсэн байна лээ. Тэр судалгаа нь бол хангалттай болсон ч гэсэн ийм ганцаарчилсан асуулга буюу суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа нь хангалттай бас .../минут дуусав/

Б.Жаргалан: Ундраа гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүнийг бас нэмье. Тэгээд Туваан гишүүний микрофон. Туваан гишүүн асуулт асууя. Асуулт асуух гишүүдийн жагсаалтад Туваан гишүүнийг нэмээд, микрофоныг нь нээе.

Ц.Туваан: Тэгээд энэ Халзан бүрэгтэйн асуудлаар сонсгол явагдсан. Тайлангаа бас харьяа Байнгын хороод танилцаж байна. Энэ газрын ховор элемент гээд нэрлэчихсэн байгаа энэ зүйлээ бид хэд нэлээн нухацтай судалмаар юм байна лээ. Нэршил дээрээс нь эхлээд яримаар юм байна лээ. Одоо бид нар чинь нүүдэлчин хүмүүс Монголчууд газрын ховор гээд л жишээ нь учиргүй ховор юм гэж ингэж ойлгодог. Критикал минерал гээд нэрлэчихдэг. Чухал ашигт малтмал гэхихдэг. Чухал юм байна гээд тэгэхээр бид нар энийг бол олон улсын нэршилд нь тэргүүлэх ач холбогдолтой ч гэдэг юм уу, үйлдвэрлэлд тэргүүлэх ач холбогдолтой уул уурхайн бүтээгдэхүүн гэдэг юм уу иймэрхүү байдлаар эхлээд яримаар байгаа юм. Хууль, эрх зүйн хувьд нь бол энийгээ ингэж яримаар байна.

2 дугаарт нь бол энэ дэлхий чинь газрын ховор элементээр амьсгалж байдаг. Монгол бүүр алсарч байдаг. Зугтааж байгаа. Бид нар сая төсөв хэлэлцээд дууслаа. Нөгөө ахмадуудын тэтгэвэр, багш нар, эмч нарын цалин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ халамжийн асуудлыг шийдэх гэж сая арай л төсвөө задалчихсангүй. Тэгэхээр юу хэлэх гээд байна гэхээр бид нарт байгаа дэлхийд гаргаад валют олж болох цөөхөн юм байгаа. Бид нарт жоохон нүүрс байна. Тэгээд хэрүүлтэй, уруултай алт байна. Тэгээд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дундаас жин дарах нь ноолуур байна. Ингээд л өөр юм байхгүй. Тэгэхээр энэ газрын овор элемент гэдгийг чинь дэлхий дээр бараг уул уурхайн ярьдаг 10 хүн байлаа гэхэд 7, 8 нь ярьдаг болчихоод байгаа энэ цаг үед бид нар энэнээс маш их хоцорч байна. Энэ бол харамсалтай байна. Бид нар өнөөдөр газрын ховор элементийн лицензийнхээ асуудлыг хүртэл шийдэж чадахгүй байгаа шүү дээ. Ерөнхийлөгчийн зарлигтай. Засгийн газар дээр шийднэ гэхихсэн. Тэгээд хууль нь байхгүй. Энэ нь газар ховроор компани нэмж лиценз авах ямар ч боломжгүй байгаа гэх мэтчилэн ийм олон ярих асуудал байна. Тэгэхээр энэ дээр бид нар улс төржилгүйгээр нэлээн тийм эдийн засаг талаасаа хараад ажиллах ёстой. Мэдээж тэр аюулгүй байдал энэ тэр ашиглалтын үед хариуцлагатай уул уурхайн кодексуудыг мөрдөх энэ тэр асуудал бол мэдээж байлгүй л яах вэ.

2 дугаарт энэ хамгийн их буруутай хүмүүс бол улс төрчид бид нар өөрсдөө. Юу юугүй очоод л хортой, цөмийн цацраг идэвхт ашигт малтмалын хольцтой энэ тэр гээд л ярьдаг. Тэгээд би энэ Халзан бүрэгтэйн ордыг бас олон улсын судалгаа дээрээс нь харж байхад Уран, торины хэмжээ хамгийн бага талаасаа 3-д ороод эрэмбэлэгдчихсэн байдаг юм байна лээ шүү дээ. Энэ олон улсын судалгаанууд байна. 1 минутаа авчихъя.

Б.Жаргалан: Туваан гишүүнд нэг минут нэмж өгье.

Ц.Туваан: Тэгэхээр бид нар энийгээ болохоор хэд дахин өндөр гээд ингээд сурталчилчихсан. Тэрийг нь манай иргэд буруугаар ойлгочихсон. Ингээд өөрөө өөрсдөдөө чөдөр тушаа болоод байна. Уг нь бол манай олон улсын геополитикийн нөхцөл хүндэрчихсэн байгаа энэ цаг үед Монгол Улсын гартаа бариад улсуудтай ярилцах нэг зэвсэг болгож, 1 бүтээгдэхүүн болгож ашиглах юм чинь энэ байхгүй юу. Одоо дахиад 3 жил, 4 жил өнгөрөөд бид нар энийгээ бараг мартана даа. Энэ хөгжлөөс хурдцаас бид нар хоцроод үлдчихнэ. Тэр байтугай бид нар ашиглаад сурчихсан энэ алтаа хүртэл ингээд 1гр алт 500 мянган төгрөг, унац алт 4 мянган доллар давж байхад ашиглаж чадахгүй алдаж л байгаа байхгүй юу. Тэгэхээр газрын ховор дээр бол бас л нэлээн алдах байх. Тэгэхээр энэ асуудлуудаа нээлттэй яриад, хууль тогтоогч нар нь Засгийн газар нь арга хэмжээг яаралтай авах шаардлагатай л гэсэн үг хэлье.

Б.Жаргалан: Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Туваан гишүүнтэй бас санал нэг байна. Ер нь тэгээд бас өмнө нь та бас сайдаар, салбарын сайдыг хэсэг хугацаанд хариуцсан хүн. Ер нь улс төрчид бид нар буруутай. Орон нутагт нь очоод янз бүрийн байдлаар зөв ойлголт өгөхөөсөө илүүтэйгээр ард иргэдэд таалагдах байдлаар ингээд сонгуулийн цаг хугацаа дөхчихсөн үед ялангуяа бас янз бүрийн байдлаар ингээд хандлага хандсан зүйлүүд бол ажиглагдсан. Тэгээд өнөөдөр энэ сонсгол өөрөө их үр дүнтэй байх ёстой гэж би харсан. Гарч байгаа энэ дүгнэлт, тайлан эндээс бол жишээлбэл манай энэ хамтарсан Байнгын хороод, парламент өөр дээрээ энэ хууль, эрх зүйн орчныг нь тодорхой болгох ийм үүргийг хүлээх ёстой. Иргэдэд маш зөв газрын овор элементийнхээ ойлголтыг их зөв өгч, энэ төр хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг нь ойлголцлыг нь хийх ажлыг нь салбарын яам нь хариуцаж хийх ёстой. Тусгай зөвшөөрлийг салбарын яам олгож байгаа шүү дээ. Тэгэхээр тэр тусгай зөвшөөрөл олгосон юм бол тэр салбарын яам тэр дээрээ бас хариуцлагатай хандах. Одоо иргэдтэй ингээд уулзаад газрын ховор гэхээр их айхтар зүйл гэж бодоод байгаа юм. Одоо Туваан сайд яг л хэлж байна. Тэр ховор, яг нарийн яривал энэ чинь хамгийн элбэг л зүйл байгаад байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр энэ бид нарын энэ үзэж байгаа дэлгэц, гар утасны дэлгэц гээд хамгийн наад захын бүтээгдэхүүн энэ газрын ховроос гарч байдаг. Онгоцны моторын хамгийн ачаалал даадаг соронзлог бүтээгдэхүүн нь газрын ховроос гарч байдаг гэх мэт ийм олон бүтээгдэхүүнүүд нь газрын ховроос гардаг ийм боломжтой зүйл байгаа.

Тэгээд энэ дээр төр бол ер нь улс төржилтийг хойш нь тавьж байгаад, явцуу ашиг сонирхлоос тойрч гүйж байгаад бодлогоо гаргаад, асуудлаа шийдчихвэл энэ улс эх орны эдийн засаг, иргэдийн амьдралд хэрэгтэй л шийдвэр гарах болов уу гэж харж байгаа. Санал нэг байна.

Б.Жаргалан: Тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Уянга гишүүнээр тасалъя. Уянга гишүүн.

Б.Уянга: Халзан бүрэгтэйн ордтой холбоотой хяналтын сонсголын тайланг өнөөдөр хэлэлцэж байгаад бол их баяртай байна. Үр дүнг нь сонсоод бас хэд хэдэн зүйлийг бас давтаад түрүүн гишүүд ч бас асуугаад хариултаа авчих шиг боллоо. Хэлээд дүгнэе л гэж бодсон юм. Тэгээд яах вэ, зүгээр энэ хяналтын сонсгол дээр 3 гол зүйлийг манай шинжээчид гаргаад, хяналтын сонсголоор хэлэлцүүлээд мэдээллээ авсан байна гэж харж байгаа. Тэгээд яах вэ, яг энд бол салбарын сайдаар ажиллаж байсан Туваан сайд бол нэлээн санал нэгдэж хүлээж авах байх

гэж бодож байна. Ер нь ашигт малтмалын хайгуулыг олборлолттой, ашиглалттай холиод байдаг нь л их тийм том асуудал.

Одоо яг энэ Халзан бүрэгтэй орд дээр байгаа тусгай зөвшөөрөл нь ашиглалтын тусгай зөвшөөрөл. Гэхдээ 2006 онд Ашигт малтмалын тухай хууль шинэчилж найруулагдахаас өмнө олгогдсон буюу тухайн үед бол өргөдөл өгөөд л ашиглалтын тусгай зөвшөөрөл авдаг байх үеийн тусгай зөвшөөрөл. Гэхдээ хайгуулын ажил нь гүйцэд хийгдээгүй. Тэгээд одоо бол энэ тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажлаа хийгээд, гүйцээгээд өнөөдрийнхөө түвшинд нь хүргээд ингээд явж байгаа ийм судалгааны ажил юм. Тэгэхээр ер нь яг нийт ард иргэддээ хандаад хэлэхэд ашигт малтмалын хайгуулын үе шат бол 10-15 жил үргэлжилдэг. Үүний дараа олборлолт руу шилждэг. Олборлолт руу шилжихийн тулд тухайн нутагт буюу Ховд аймгийн Мянгад сумд дэд бүтцийн бас өндөр шаардлага тавигдана. Тэгэхээр одоо хайгуулаа хийгээд дуусна. Дараа нь яг олборлолтод шилжих үү, үгүй юү гэдэг нь тухайн ордоосоо шалтгаалахгүй. Тэнд газрын ховор элемент олборлох гэж байна уу гэдгээс үл шалтгаалан өөр бас зөндөө тээвэр логистикийн асуудлууд гараад ирнэ. Тэгэхээр энэ төслийг ямартай ч цааш нь хайгуулын ажлыг нь үргэлжлүүлэе гэсэн дүгнэлт энэ тайлан дээр гарч ирсэн байгаад бол баяртай байна.

Хоёрдугаарх нь болохоор газрын ховор элементийг энэ Халзан бүрэгтэйн ордыг газрын ховор элементийг олборлох гээд байхад нь уран олборлох гэж байна гээд маш их тийм ташаа мэдээлэл явчихсан. Тэгэхээр яг бас энэ сонсголын тайлан дээр энэ одоо яг 2 тусдаа юм. Газрын ховор элемент Халзан бүрэгтэйн ордын ерөнхий хайгуул хийж байгаа төлөвлөгөө нь эндээс олдох боломжтой ашигт малтмал нь яг үелэх системийн тэр лантунойдын бүлэгт багтдаг элемент юм. Ураныг ерөөсөө яриагүй юм гэдэг нь ялгагдаж, ялгаатай гарч ирж байгаа нь бол бас их сайшаалтай байна. Энэ бас яг мэдээллээ тусад нь сайн мэдэхгүй байгаа хүмүүст хэрэгтэй гэж бодож байна.

3 дахь том асуудал нь болохоор төр тусгай зөвшөөрөл олгосон бол хамгаалдаг байх ёстой гээд. Тэгээд уг нь бол АМГТГ 2021 онд байна уу даа 7 бүсэд яг энэ мэдээллийг иргэдээ мэдээлэлжүүлэх хүрээнд багуудыг ажиллуулж, салбаруудыг гаргасан юм. АМГТГ дээр. Тэгээд баруун бүсийнх нь Завхан аймагт байна уу даа. Тэгэхээр энд л нөгөө төсвийг нь хангалттай тавьж өгдөггүй. Бараг машин ч байхгүй. Тэгээд ингээд явж очоод тайлбарлая гэхээр бас болдоггүй ийм асуудал байдаг. Энэ дээр бас Дамдинням сайд нэлээн анхаарч байх шиг байсан. Үргэлжлүүлээд Улсын Их Хурлын гишүүд бас дэмжээд өгвөл.

Сүүлд нь хэлэх зүйл нь яах вэ, уул уурхайн төслүүдийг ингээд 1, 1-ээр нь Улсын Их Хурал дээр хяналтын сонсгол хийхийг бол яг хувь хүний хувьд бол дэмжихгүй байгаа. Гэхдээ мэдээж иргэдээ мэдээлэлжүүлэх ёстой. Яагаад дэмжихгүй байгаагаас шалтгаан нь энэ хяналтын сая Халзан бүрэгтэйн сонсголотой холбоотой байсан юм. Яг сонсгол хийх үеэр ингээд Ховд аймгаас маш олон иргэд ирчихсэн байсан. Тэгтэл Ховд аймгийн Мянгад сумын Засаг дарга нь байдаггүй, Иргэдийн Хурлын дарга нь байдаггүй. Тэгэхээр мэдээж аймгийн дарга нар нь байхгүй. Тэгэхээр бүх оролцогч төрөө төлөөлөөд Ховд аймагт байгаа тэр Засаг дарга, Иргэдийн Хурлын дарга нар нь байхгүй байсан. Энэ их харамсалтай. Энийг бас анхааруулаад, дараа хэрвээ Улсын Их Хурал дээр аль нэг аймаг, сумын хамарсан төсөл дээр сонсгол хийх гэж байгаа бол заавал энэ удирдлагуудыг байлгадаг байх дээр анхаарах хэрэгтэй гэж бодож байна.

Б.Жаргалан: Халзан бүрэгтэй орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцэх хэлэлцүүлэг үүгээр өндөрлөж байна. Өөр горимын саналтай гишүүд байхгүй. Хэлэлцүүлэг дууслаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байгаа. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд та бүхэндээ баярлалаа.

12.08 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ